# 1.2 Суралцагчийн төлөв баталгаажуулах

Энэхүү үйлдлийг тухайн цэцэрлэгт суралцагч шилжиж ирэх, шинээр элсэн орох болон **батлагдаагүй** төлөвтэй байгаа суралцагчийг **батлагдсан** төлөвтэй болгох үед ашиглана.

Суралцагчийн төлөв баталгаажуулах үйлдлийг дараах дараалаар хийнэ. **Үүнд**:

1. **Суралцагч** ерөнхий цэсийг сонгоно.
2. **Батлагдаагүй** төлөвтэй суралцагчийн сонгоно.
3. Цонхны баруун дээд буланд байрлах үйлдэл цэснээс **баталгаажуулах** хүсэлт үйлдлийг сонгоно.

Суралцагчийн төлөв баталгаажуулах үйлдлийн дэлгэрэнгүй тайлбар:

1. **Суралцагч** ерөнхий цэсийг сонгоно.




2. **Батлагдаагүй** төлөвтэй суралцагчийн сонгоно.




3. Цонхны баруун дээд буланд байрлах үйлдэл цэснээс **баталгаажуулах** хүсэлт үйлдлийг сонгоно.




**Баталгаажуулах хүсэлт** үйлдлийг хийхэд төлөв дараах байдлаар өөрчлөгдөнө.

| **Төлөв** | **Тайлбар** |
|---|---|
| **Батлагдсан** | Батлагдсан төлөв нь бүртгэгдэж баталгаажсан суралцагч юм. |
| **Хянагдаж байгаа** | Суралцагч нь 6-аас доош настай эсвэл суралцах түвшин зөрүүтэй ангид бүртгэл хийсэн тохиолдолд "Хянагдаж байгаа" төлөвт орно. |
| **Цуцлагдсан** | БСУГ болон БШУЯ-ны хариуцсан мэргэжилтэн суралцагчийн материалыг шалгаж үзээд шаардлага хангаагүй гэж үзсэн тохиолдолд суралцагчийн мэдээлэлд цуцлах үйлдлийг хийснээр **"Цуцлагдсан"** төлөвт шилжинэ. |

**<u>Анхаарах</u>:**

**Хянагдаж байгаа** төлөвт орсон бол хариуцсан БСУГ-ын (нийслэлийн сургуулиуд Нийслэлийн

боловсролын газрын мэргэжилтэн) болон БШУЯ-ны мэргэжилтэн суралцагчийн материалыг шалгаж хянах шаардлагатай гэсэн үг.  Өөрөөр хэлбэл 2 түвшний баталгаажуулалтыг хийнэ. Иймд сургуулиуд суралцагчийг сургуульдаа авч байгаа тайлбар, батлах бичиг баримтыг дээрхи 2 мэргэжилтэнд илгээж шалгуулах шаардлагатай.

**Цуцлагдсан** төлөвт орсон суралцагчийг **Үйлдэл буцаах** үйлдлээр сургуулийн бүртгэлээс хасаж зөв анги бүлэгт дахин бүртгэж авах эсвэл батлах бичиг баримт материалыг бүрэн гүйцээж дахин баталгаажуулах хүсэлт илгээх үйлдлийг хийх боломжтой.